

суугаа улс, бүс нутаг

Япон

Сургуульд элсэх өргөдөл гаргах/ Шалгалт өгөх

Элсэх хүсэлтэй сургуульдаа
сургуульд элсэх өргөдөл гаргахад
шаардлагатай бичиг баримтыг
илгээж, шалгалт өгнө. (Японд
шалгалт өгөх шаардлагатай бол
Японд ирнэ.)



Элсэх хүсэлтэй сургууль
(Японд суралцах сургууль)

Сургуульд элсэх зөвшөөрлийн бичиг хүлээн авах

Виз мэдүүлэх бичиг баримт
бүрдүүлэхэд шаардлагатай болно.
Сайтар хадгалаарай.



Сургуульд элсэх зөвшөөрлийн бичиг илгээх

Элсэх хүсэлтэй сургууль (Японд суралцах сургууль) нь тэнцсэн элсэгчид сургуульд элсэх зөвшөөрлийн бичгийг илгээнэ.

Оршин суух зөвшөөрлийн гэрчилгээ (СОЕ) олгохыг мэдүүлэх

Таны төлөөлөгч (Элсэх хүсэлтэй сургууль гэх мэт) эсвэл та (Японд суралцах хүсэлт гаргагч) орон нутгийн хилийн шалган нэвтрүүлэх хяналтын албанд СОЕ олгохыг мэдүүлнэ.



Орон нутгийн хилийн шалган нэвтрүүлэх хяналтын алба



Оршин суух зөвшөөрлийн гэрчилгээ (COE) хүлээн авах

Таны төлөөлөгч (Элсэх хүсэлтэй сургууль гэх мэт) рүү Орон нутгийн хилийн шалган нэвтрүүлэх хяналтын албанаас СОЕ-ийг илгээнэ.

Оршин суух зөвшөөрлийн гэрчилгээ (COE) хүлээн авах, виз мэдүүлэх

СОЕ-ийг хүлээн авсны дараа виз мэдүүлэхэд шаардлагатай бичиг баримтаа цуглуулж, өөрийн эх орон эсвэл амьдарч байгаа улс, бүс нутагдахь Япон улсын Элчин сайдын яам зэрэгт виз мэдүүлнэ.



Оршин суух зөвшөөрлийн гэрчилгээ (COE) илгээх

СОЕ олгогдмогц, элсэх хүсэлтэй сургууль (Японд суралцах сургууль) зэрэг нь тань руу СОЕ-ийн эх хувийг илгээнэ.



**Танай улс дахь Японы улсын
элчин сайдын яам**



Японд ирэх, Японы хил нэвтрэх зөвшөөрөл мэдүүлэх

Хилээр нэвтрэхэд паспорт, виз, СОЕ-ийн эх хувь шаардлагатай. Сургуульд элсэх зөвшөөрлийн бичгээ үзүүлэхийг шаардах тохиолдол байдаг. Нисэх онгоцны буудал дээр хил нэвтрэх зөвшөөрөл хүснэ.



Орон нутгийн хилийн шалган нэвтрүүлэх хяналтын алба

Шинчитосэ, Нарита, Ханэда, Чюүбү,
Кансай, Хирошима, Фүкүока нисэх
онгоцны буудлуудаас хилээр
нэвтэрч, оршин суух хугацаа нь 3
сараас дээш бол, хил нэвтрэх
зөвшөөрөл гармагц оршин суух
үнэмлэх олгогдоно.



Япон дахь оюутны амьдралын эхлэл!